

“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ

Огноо: 2019.08.28

**Өвлийн ажлын гутал НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Өвлийн ажлын гутал

**Төслийн дугаар:** ХТГОНӨААТҮГ/201901056

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ӨВЛИЙН АЖЛЫН ГУТАЛ**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын гудамж, өөрийн байр 108 тоот** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 11 цаг 00 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Баянзүрх дүүрэг, Залуучуудын гудамж, өөрийн байр  
108, Ц.Батцэцэг, 90130066**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн саналыг маягтын дагуу, баталгаажуулж ирүүлэх.</li> <li>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх.</li> <li>3. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байна.</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг эх хувиар ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</li> <li>5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харъяа Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг эх хувиар ирүүлэх.</li> <li>6. Харилцагч банкны тодорхойлолт ирүүлэх.</li> <li>7. 2018 оны санхүүгийн тайлан ирүүлэх.</li> <li>8. Сүүлийн 2 жилд ижил төстэй бараа нийлүүлсэн тухай мэдээлэл ирүүлэх. /гэрээний хуулбар мөн бараа хүлээлцсэн акт эсвэл гэрээ дүгнэсэн акт. /</li> <li>9. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын зүгээс тухайн тендерт оролцогчийн талаар харилцагч банк, харъяа татвар, шүүх болон бусад байгууллагад хандаж лавлагаа хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>10. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх.</li> <li>11. Барааны загвар эсвэл барааны зургийг ирүүлэх.</li> <li>12. Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй.</li> <li>13. Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна.</li> <li>14. Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.</li> </ol> <p>ТШӨХ-т заасан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д цахим хэлбэрээр</b> хүлээн авна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><b>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын гудамж, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, 108 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх.</li> <li>2. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байна.</li> <li>3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг эх хувиар ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</li> </ol>

	<p>4. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харъяа Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг эх хувиар ирүүлэх.</p> <p>5. Харилцагч банкны тодорхойлолт ирүүлэх.</p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b><i>Багцгүй</i></b>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** Ажлын гутал нь хүйтэн нөхцөлд ажиллахад зориулагдсан, тос, ус чийг, тоос шороо, химийн бодис, шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй, чийг татдаггүй байх ба **арзгар, зузаан халтирахгүй ултай, хурууны хамгаалалттай, хөдөлгөөнд саадгүй түрийн зохион** байгуулалттай, бат бөх, цахилгаан дамжуулдаггүй байх шаардлагатай.

№	Барааны нэр	Техникийн шаардлага
1	Өвлийн ажлын гутал	<ul style="list-style-type: none"> <li>- Хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй.</li> <li>- Өвлийн гутал нь <math>-30^{\circ}\text{C}</math>-ээс <math>-40^{\circ}\text{C}</math> хүртэлх температурт өмсөхөд зориулагдсан, арьсан материалтай, хөлддөггүй, нэхий дотортой байна.</li> <li>- Тос, ус чийг, тоос шороо, химийн бодис болон шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй, чийг татдаггүй, цахилгаан дамжуулдаггүй, бат бөх хийцтэй байх.</li> <li>- Гутлын ул хөлдөхгүй хагарахгүй, зузаан, хайрахгүй дулаан хадгалдаг байх.</li> <li>- Хөдөлгөөнд саадгүй түрийн зохион байгуулалттай байх.</li> <li>- Хатуулгатай зуузайтай, давхар оёдолтой байна.</li> <li>- Хүйтэн цас бороонд тэсвэртэй сайн чанарын бүрэн боловсруулсан ширэн материалаар хийгдсэн эдэлгээ даах бөх бат байх.</li> <li>- Үдээсгүй, богино түрийтэй байх.</li> </ul>

- 2. Стандарт:** Өвлийн ажлын гутал нь “Хөлний хамгаалалт ажлын тусгай гутал MNS 5623:2006” стандартын шаардлагыг хангасан байна.

- 3. Баглаа, боодол:** Ус чийг, тоос шороо нэвтрэхээс хамгаалсан зориулалтын гэрэлтдэг савлагаатай байх ба бараа тус бүрт хувцасны хэмжээг харагдахуйцаар тэмдэглэсэн байна.

- 4. Бараа хүргэх газар:** Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Тохижилт үйлчилгээний албаны агуулах /Хаяг: Баянзүрх дүүргийн 15-р хороо/-т нийлүүлэгч өөрийн зардлаар хүргэж буулгана.

- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Өвлийн ажлын гутал	Арзгар, зузаан халтирахгүй ултай, хурууны хамгаалалттай, хөдөлгөөнд саадгүй түрийн зохион байгуулалттай	305	Хос	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Тохижилт үйлчилгээний албаны агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Ажлын хувцсыг комисс хүлээн авч шалгасны дараа актаар хүлээлцэнэ.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>4) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Баталгаат засварын хугацаа ашиглалтанд өгснөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна.</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>100</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | <p>9.1. Алданги оногдуулах хувь: хэтэрсэн хоног тутам <b>0,05 хувь</b></p> <p>Алдангийн нийт дүн: гэрээний үнийн дүнгийн <b>10</b> хувиас хэтрэхгүй байна.</p>  |

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*